МЭДЭЭ · 2024 оны 6-р сарын 12

ДҮНЖИНГАРАВЫН УУЛЗВАРТ ГАРСАН ГАЛЫН УЛМААС 5.4 ТЭРБУМ ОРЧИМ ТӨГРӨГИЙН ХОХИРОЛ УЧИРЧЭЭ



Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах "Дүнжингарав" худалдааны төвийн замд энэ оны 1 дүгээр сард гарсан галын хэрэгт Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах алба, Тээврийн цагдаагийн алба хамтарсан ажлын хэсгээс мөрдөн шалгах ажиллагаа явуулж, Нийслэлийн прокурорын газраас хяналт тавьж ажиллаж байна. **/энд дарж үзнэ үү/**

Ажлын хэсгээс гал гарсан шалтгаан нөхцөл, учирсан хохирлын хэр хэмжээг тогтоохоор 6 төрлийн 62 шинжилгээ хийлгэхээр шинжээч томилж 60 орчим дүгнэлтийг гаргуулжээ.

Галын улмаас онцгой байдлын газрын 3 албан хаагч, явган болон автомашинаар зорчиж явсан 4 иргэн нас барж, 9 хүн хөнгөн, хүнд гэмтэж, 26 иргэнд угаарын хийн хөнгөн зэргийн хордлогын шинж илэрсэн бол 36 тээврийн хэрэгсэл, 3 барилга байгууламж шатаж, 228 иргэн, 15 аж ахуйн нэгж байгууллагын эд хөрөнгөд 5.4 тэрбум орчим төгрөгийн хохирол учирсан болох нь тогтоогдсон байна.

Одоо хэргийн нөхцөл байдлыг бүрэн тогтоохоор мөрдөн шалгах ажиллагааг

үргэлжлүүлэн явуулж байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1221